

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны ... дугаар
сарын ...ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Мах, махан бүтээгдэхүүний экспорт, импортын
тоо хэмжээний тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2021 оны дүгээр сарын-ны өдрийн дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Адуу, хонь, ямааны түүхий мах, хонь, ямааны дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний экспорт болон үхрийн махны импортод 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд экспортлох үхрийн түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

3. Энэ тушаалын 2 дахь заалтад тусгасан үхрийн түүхий мах болон дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Л.Чой-Иш)-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д тус тус даалгасугай.

4. Импортлогч орны мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн мал, махны гарал үүслийн тодорхойлолтод үндэслэн мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжтэй тухай бүр Бодлогын гэрээ байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

Гарын үсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2021 оны дугаар сарын -ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

2021-2022 ОНД ЭКСПОРТЛОХ ҮХРИЙН ТҮҮХИЙ БОЛОН ДУЛААНЫ АРГААР
БОЛОВСРУУЛСАН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Малын мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсвэл хөргөсөн мах	0201.10.00	1000 тн (нэг мянга)
		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсвэл хөргөсөн мах	0201.20.10	
		Сарлагийн ястай нь хэсэглэсэн шинэ эсвэл хөргөсөн мах	02.01.20.20	
		Үхрийн ясгүй шинэ эсвэл хөргөсөн мах	0201.30.10	
		Сарлагийн ясгүй шинэ эсвэл хөргөсөн мах	0201.30.20	
		Үхрийн гулууз болон өрөөл хөлдүү мах	0202.10.00	
		Үхрийн ястай нь хэсэглэсэн хөлдүү мах	0202.20.10	
		Сарлагийн ястай нь хэсэглэсэн хөлдүү мах	0202.20.20	
		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
		Сарлагийн ясгүй хөлдүү мах	0202.30.20	
		2	Дулааны аргаар боловсруулсан мах	